



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар #120

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Батлан хамгаалахын сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/175 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг халах, татах ажлыг зохион байгуулахад шаардагдах 7,491,580 (долоон сая, дөрвөн зуун ерэн нэгэн мянга, таван зуун наян) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн бэлтгэл сургууль, цугларалт, зориулалтын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР